



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын гуравдугаар хавсралтын 3, 14 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт

2.Нийцлийн аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хариу ирүүлэхийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга (Д.Ихбаяр), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар) нарт зөвлөсүгэй.

3.Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2027 оны нэгдүгээр улиралд танилцуулахыг Гүйцэтгэл, нийцлийн аудит хариуцсан ахлах менежер (Ч.Болд)-д үүрэг болгосугай.

4.Тайланг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч-д хүргүүлсүгэй.



Г.НАНДИНЖАРГАЛ



Аудитыг гүйцэтгэсэн:	ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	2
	ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
	ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	3
	ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	3
	ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	4-5
Нийслэл дэх Төрийн аудитын газар	ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6-7
Гүйцэтгэл, нийцлийн аудит хариуцсан ахлах менежер Ч.Болд	Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?	8
Гүйцэтгэлийн аудитын алба	1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө бодлогын баримт бичигтэй уялдуулсан уу ?	8
Аудитын менежер Б.Номинбаатар	1.2 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуульд заасан ТЭЗҮ, батлагдсан зураг төсөв, төсөвлөлтийн холбогдох бусад шаардлагыг хангасан, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн төсөл, арга хэмжээг тусгасан уу?	8-10
Ахлах аудитор Ж.Жавзанпагма	1.3 Төсвийн төлөвлөлтөд төрийн аудитын байгууллагын тухайн жилийн төсвийн төсөлд өгсөн санал, дүгнэлтийг тооцсон уу, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн үү?	10-12
Аудитор А.Сэлэнгэ С.Алтандэлгэр	Бүлэг 2. Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?	13
	2.1 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох хууль, журамд нийцсэн төсөл, арга хэмжээг тусгасан уу?	13
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө “Г” корпус, Утас: 70007734	2.2 Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан уу?	13-14
	Бүлэг 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн өмч бүртгэлд тусгасан уу?	15
	3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн үү?	15-17
Тайланг НТАГ-ын http://audit.mn/ веб сайтаас үзнэ үү.	3.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, гэрээний биелэлтэд хяналт тавьж байна уу?	17-22
	3.3 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна уу?	22-25
	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН САНАЛ	26-27
	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР	28
	АУДИТЫН ДҮГНЭЛТ	29
	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	30
	ХАВСРАЛТУУД	31-70



ТОВЧИЛСОН ҮГС ИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үгс	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
ЗГ	Засгийн газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НЗХГ	Нийслэлийн Замын хөгжлийн газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
НЭМГ	Нийслэлийн Эрүүл мэндийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ХК	Хувьцаат компани
ЧД	Чингэлтэй дүүрэг



№ Хүснэгтийн жагсаалт		
1	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний өөрчлөлт (ангиллаар)	6
2	Шинээр хэрэгжих ТАХ-ний бодлогын уялдаа	8
3	ТАХ-ний төсөвлөлтийн шаардлагын хэрэгжилт	9
4	Төсвийн төсөл болон батлагдсан төсвийн харьцуулсан үзүүлэлтүүд	11
5	Шууд гэрээ байгуулсан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн жагсаалт	16
6	Гэрээ байгуулагдсан төсөл, арга хэмжээ	17
7	ТАХ-ний гэрээний хэрэгжилт	17
8	Газар чөлөөлсөн талбайн ашиглалт (Ажлын явцаар)	22
9	ТАХ-ний үр дүнд үүссэн хөрөнгийг өмч бүртгэлд тусгасан байдал	23
10	Тоног төхөөрөмж нийлүүлэлт, өмчийн бүртгэлийн байдал	24
№ Дүрслэлийн жагсаалт		
1	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг (2022-2025)	7
2	Батлагдсан төсөл, арга хэмжээний тоон үзүүлэлт	7
3	ТАХ-ний тоогоор	11
4	ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжилтээр	11
5	ТАХ-ний санхүүжилт	15
6	Захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллагуудын ТАХ, санхүүжилтийн эзлэх хувь	18
7	Гэрээний сунгалт	18
8	ТАХ-ний хэрэгжилт тоогоор	24
№ Хавсралтын жагсаалт		
1	Зураг төсөвгүй, МЕД-н хугацаа дууссан байхад баталсан ТАХ	31-33
2	Техникийн тодорхойлолтгүй ТАХ	33-35
3	Ажлын тоо хэмжээ, төсвийн тооцоолол тодорхойгүй ТАХ	35-36
4	Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, орон нутгийн өмчид шилжих боломжгүй ТАХ	36-37
5	5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш тендер нээж, гэрээ байгуулсан ТАХ	37-40
6	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-нд олгосон санхүүжилт	40-43
7	Гэрээний хугацаа хэтэрсэн алданги тооцоогүй	43-43
8	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ	44-49
9	Гэрээ цуцалсан ТАХ	49-50
10	Захиалагчийн хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн ТАХ	50-52
11	Өмчид бүртгэгдээгүй ТАХ	52-70



ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 7 дугаар зүйлийн 7.1, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/174 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “НТАГ-ын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго, зорилт

Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг НЗД болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү;
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн өмч бүртгэлд тусгасан уу.

Аудитын хамарсан хүрээ

Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар баталсан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилтийг зохион байгуулсан НЗД, НЗДТГ болон харьяа байгууллагуудыг хамруулан төлөвлөлтийн баримт бичиг, ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, хэрэгжилтийг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашигласан.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

- Авто замын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;



- Төсвийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах дүрэм”;
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Засгийн газрын 2024 оны 91 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам”;
- Сангийн сайдын 2023 оны 250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 тогтоолоор баталсан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- НИТХ-ын 2025 оны төсөв баталсан тогтоолууд;
- НТАГ-аас “Нийслэлийн 2025 оны төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлт”;
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт;
- Өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрүүд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Гүйцэтгэл, нийцлийн аудит хариуцсан ахлах менежер Ч.Болд хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Б.Номинбаатар хэрэгжүүлэн, ахлах аудитор Ж.Жавзанпагма, аудитор А.Сэлэнгэ, С.Алтандэлгэр нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитад учирсан хүндрэл, бэрхшээл

ТАХ-ний хэрэгжилтийн бодит байдалд аудит хийхэд аудитын багийн гишүүдийн мэргэжил, хүний нөөцийн хүрэлцээгүй байдал, шалгагдагч байгууллага шаардсан мэдээллийг хугацаа алдаж, бүрэн бус ирүүлсэн зэрэг нь хүндрэлтэй байсан.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

НИТХ-ын 2024 оны 24/33 дугаар тогтоолоор Нийслэлийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтад нийт 11,129.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 405 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж, 4,666.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг баталснаас шинээр эхлэх 118 төсөлд 1,944.7 тэрбум, дамжин болон шилжих 287 төсөлд 9,184.8 тэрбум төгрөгийг төлөвлөжээ.

Тайлант онд төсөвт 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, хамгийн сүүлд НИТХ-ын 2025 оны 25/132 дугаар тогтоолоор шинээр хэрэгжих 136, өмнөх оноос шилжих 348, нийт 16,713.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 484 ТАХ-г 2,926.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1. Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний өөрчлөлт

№	Шийдвэр /Тогтоол/	ТАХ-ний ангилал	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Зөрүү (Төсөвт өртөг/Санхүүжилт)
1	НИТХ-ын 24/33	Шинэ	118	1,944.7	1,362.4	Батлагдсан суурь төсөв
		Шилжих	75	3,361.5	2,546.0	
		Он дамжих	212	5,823.2	757.9	
		НИЙТ	405	11,129.5	4,666.2	
2	НИТХ-ын 25/50	Шинэ	127	3,320.4	1,412.5	↑ 4,850.9 / ↓ (281.7)
		Шилжих	136	3,244.1	2,459.1	
		Он дамжих	210	9,415.9	512.9	
		НИЙТ	473	15,980.4	4,384.5	
3	НИТХ-ын 25/70	Шинэ	126	3,299.8	1,412.5	↑ 264.9 / ↓ (106.3)
		Шилжих	137	3,264.7	2,459.1	
		Он дамжих	210	9,415.9	512.9	
		Нийт	473	15,980.4	4,384.5	
4	НИТХ-ын 25/106	Шинэ	135	3,351.3	1,416.5	↑ 465.8 / ↓ (1.1)
		Шилжих	141	3,276.5	2,451.4	
		Он дамжих	207	9,617.5	410.3	
		НИЙТ	483	16,245.3	4,278.2	
5	НИТХ-ын 25/113	Шинэ	136	3,760.5	1,423.6	↑ 1.9 / ↓ (1,351.0)
		Шилжих	141	3,333.1	2,458.1	
		Он дамжих	207	9,617.5	395.3	
		НИЙТ	484	16,711.0	4,277.1	
6	НИТХ-ын 25/132	Шинэ	136	3,761.6	1,371.6	
		Шилжих	141	3,333.5	1,159.1	
		Он дамжих	207	9,617.9	395.3	
		НИЙТ	484	16,713.0	2,926.1	


Эх сурвалж: НИТХ-ын холбогдох тогтоолууд

НИТХ-ын дээрх тогтоолуудаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинэчлэн батлахдаа ТАХ-ний тоог 79, нийт төсөвт өртгийг 5,583.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2025 оны санхүүжих дүнг анхны төлөвлөснөөс 1,740.1 тэрбум төгрөгөөр бууруулан баталсан байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 2022 онд 1,412.5 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 16,713.0 тэрбум төгрөгт хүрч 11.8 дахин өсөж, үүний 50.2 хувь буюу 8,387.8 тэрбум төгрөгийг “Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барих төслийн бүтээн байгуулалтын ажил дангаараа эзэлж байна.




Дүрслэл 1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг (2021-2025)



Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 996 ТАХ-ний санхүүжилтэд нийт 2,926.06 тэрбум төгрөг олгохоор төлөвлөснөөс 584 ТАХ-ний гүйцэтгэлд 2,034.18 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн бөгөөд үүнийг эх үүсвэрээр нь авч үзвэл нийслэлийн төсвөөс 1,313.46 тэрбум төгрөг буюу 64.57 хувь, үнэт цаасны (бонд) эх үүсвэрээс 611.1 тэрбум төгрөг буюу 30.04 хувь, нийслэлийн замын сангаас 109.6 тэрбум төгрөг буюу 5.39 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 117 ТАХ-г гүйцэтгэлийн шатанд 623 багц ТАХ болгон задалснаас шинээр эхлэх 34 төслийг 246, шилжих 29 төслийг 132, дамжих шинэ 17 төслийг 109, дамжих шилжих 37 төслийг 136 багц ажил болгон хэрэгжүүлсэн байна.

Дүрслэл 2. Батлагдсан ТАХ-ний тоон үзүүлэлт





БҮЛЭГ 1. НИЙСЛЭЛИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАСАН ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ, ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ НИЙЦЭЭГҮЙ, ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

1.1 НИТХ-ын тогтоолоор баталсан 118 ТАХ нь (задарсан 469 багц ажил) хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй бүрэн нийцээгүй байна.

1.1.1 НИТХ-ын 2024 оны 24/33 дугаар тогтоолоор Нийслэлийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 118 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд үүний 7.6-19.5 хүртэлх хувь нь хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдаагүй байна. Үүнд:

- **"2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-тэй:**
7.6 хувь буюу 9 ТАХ уялдаагүй.
- **"Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-тэй:**
9.3 хувь буюу 11 ТАХ уялдаагүй.
- **"Засаг даргын 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-тэй:**
19.5 хувь буюу 23 ТАХ уялдаагүй.

1.1.2 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 118 ТАХ-г батласны дараа нэмэлт өөрчлөлт орж, багцад задалснаар 5,697.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 469 болж нэмэгдсэн бөгөөд эдгээрийг хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан эсэхийг нягтлахад 11.5-27.5 хувь нь дунд болон богино хугацааны бодлогод нийцээгүй байна.

Хүснэгт 2. Шинээр хэрэгжих ТАХ-ний уялдаа

№	Бодлогын баримт бичгийн нэр	Нийт ТАХ-ний тоо	Уялдсан төсөл	
			Тоо / Хувь	Уялдаагүй төсөл Тоо / Хувь
1	"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"	469	415 (88.5)	54 (11.5)
2	"НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"	469	410 (87.4)	59 (12.6)
3	"Нийслэлийг хөгжүүлэх 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө"	469	340 (72.5)	129 (27.5)

1.1.3 Шинээр хэрэгжих зарим ТАХ нь дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт нэгдсэн бодлоготой бүрэн уялдаагүйг харуулж байна.

1.1.4 Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2.5-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх" гэж заасантай нийцээгүй байна.

1.2. Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих зарим ТАХ-г зураг төсөвгүй, техникийн шаардлага хангаагүй байхад багцлан задалж тоо хэмжээг 2.8 дахин нэмэгдүүлсэн байна.

1.2.1 Шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 165 ТАХ-ний 51 ТАХ-г 355 багцад задалснаар нийт хэрэгжих ТАХ 469 болж, анх батлагдсан дүнгээс 2.8 дахин нэмэгдсэн



байна. ТАХ-г ангилал тус бүрээр төсөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 3. ТАХ-ний төсөвлөлтийн шаардлага

№	Ангилал	Нийт ТАХ	Хангасан ТАХ	Хангаагүй ТАХ	
				Тоо	хувь
1	Барилга байгууламж, их засвар	232	158	74	31.9
2	Газар чөлөөлөлт	9	0	9	100.0
3	Тоног төхөөрөмж	154	102	52	33.8
4	ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	74	20	54	73.0
НИЙТ ДҮН		469	280	189	40.3

1.2.2 Барилга байгууламж, их засварын ангилалд хамаарах 5,424.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 232 ТАХ-ний 31.9 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй, үүний 25.9 хувь зураг төсөвгүй, 6.0 хувь нь магадлалын дүгнэлтийн хугацаа дууссан байна. (Хавсралт 1)

1.2.3 Газрын зөвшөөрөл шаардлагатай 10.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ нь газрын зөвшөөрөлгүй, байршил тодорхойгүй, газар чөлөөлөлт дуусаагүй байна. Үүнд:

- “Гал түймэр унтраах аврах анги (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)” барих 6,600.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- Бейсболын талбай шинээр байгуулах (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг) 1,507.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Шинээр баригдах станцуудын зураг төсөв зохиох” 1,074.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 5 багц, дэд станцын барилга барих зураг төсөл боловсруулах ТАХ;
- “Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн барилгын (ногоон барилга) зураг төсөл” 1.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ.

1.2.4 Тоног төхөөрөмж нийлүүлэх 161.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 154 ТАХ-ний 33.8 хувь буюу 52 ТАХ-г техникийн тодорхойлолтгүй баталсан байна. (Хавсралт 2)

1.2.5 Шинээр хэрэгжүүлэхээр багцлан баталсан 28 ТАХ-ний ажлын тоо хэмжээ, төсвийн тооцоолол тодорхойгүй байна. (Хавсралт 3)

1.2.6 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т заасан “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 5 дугаар сарын 31-ний дотор дуусгах” гэж заасныг зөрчиж, хуульд заасан хугацаанаас хойш төсөвт гурван удаа тодотгол хийж, 141.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 18 шинэ ТАХ-г нэмж баталжээ.

1.2.7 Шинээр хэрэгжих 62.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 38 ТАХ орон нутгийн өмчид шилжих боломжгүй байна. (Хавсралт 4)

1.2.8 Төсвийн хөрөнгө оруулалтаар холбогдох хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй, эрэмблээгүй ТАХ-г баталсан нь төлөвлөсөн хугацаанд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглаж чадахгүй байх, хугацаа алдах зэрэг үр дагаврыг бий болгож, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болж байна.



1.2.9 Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4¹, 29.4², 29¹.2.2³, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1⁴, 13.3.2⁵, 13.3.3⁶, Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1⁷ дэх заалтууд, ЗГ-ын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 2.1⁸, 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4⁹, 3.2.2.2¹⁰ дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.

1.3. НТАГ-аас НЗД-ын 2025 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой өгсөн санал, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.3.1 Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2¹¹-т заасны дагуу Нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх жилийн төсвийн төсөлд дүгнэлт гаргуулахаар 2024 оны 01/6572 дугаартай албан бичгийг НТАГ-т ирүүлсэн байна.

1.3.2 Тус танилцуулгад Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын ТАХ-ний мэдээллийг тусгасан боловч холбогдох жагсаалтыг албан бичгийн хавсралтаар баталгаажуулж ирүүлээгүй, зөвхөн цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.

1.3.3 НТАГ-аас “Нийслэлийн 2025 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах” гүйцэтгэл-нийцлийн аудитыг (НТАГ-2024/03-11-НА-НА) гүйцэтгэж, тайланг Тэргүүлэх аудиторын 2024 оны А/39 дүгээр тушаалаар баталгаажуулан НИТХ болон НЗД-д хүргүүлжээ.

1.3.4 Нийслэлийн Засаг даргаас Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр 10,428.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 5,029.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 371 ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнийг НИТХ-аас төсөв баталсан тогтоолуудыг харьцуулахад дараах байдалтай байна.

¹ 29.3.4-т “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах”

² 29.4. “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”;

³ 29¹.2.2.Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

⁴ 13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

⁵ 13.3.2.хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;

⁶ 13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.

⁷ 12.1.1.эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх;

⁸ 2.1. Зураг төсөл нь Барилгын тухай хуулийн 12, 15 дугаар зүйл болон холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.

⁹ 3.1.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2, 3.1.3-т заасан төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна

¹⁰ 3.2.2.2. “Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх”;

¹¹ 6.3.2.Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-д өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал, Засгийн газар болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх;




Хүснэгт 4. Төсвийн төсөл болон батлагдсан төсвийг харьцуулсан үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)


№	НИТХ-ын тогтоол	ТАХ-ний ангилал	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Зөрүү		
						ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	НТАГ-т ирүүлсэн 2025 оны төсвийн төсөл	Шинэ	95	1,855.1	1,360.9	41	1,906.5	10.7
		Шилжих	75	3,359.5	2,697.5	66	(26.0)	(1,538.4)
		Он дамжих	201	5,213.4	971.2	6	4,404.5	(575.9)
		Нийт	371	10,428.0	5,029.6	113	6,285.0	(2,103.6)
2	НИТХ-ын 2024 оны 24/33 дугаар тогтоол	Шинэ	119	1,946.3	1,362.4	24	91.1	1.4
		Шилжих	75	3,361.5	2,546.0	0	2.1	(151.4)
		Он дамжих	212	5,823.2	757.9	11	609.8	(213.4)
		Нийт	406	11,131.0	4,666.2	35	703.0	(363.4)
3	НИТХ-ын 2025 оны 25/113 дугаар тогтоол	Шинэ	136	3,761.6	1,371.6	17	1,815.4	9.3
		Шилжих	141	3,333.5	1,159.1	66	(28.1)	(1,386.9)
		Он дамжих	207	9,617.9	395.3	-5	3,794.7	(362.5)
		Нийт	484	16,713.0	2,926.1	78	5,582.0	(1,740.2)

1.3.5 НТАГ-аас дүгнэлт гаргасан 371 ТАХ-ний тоог 23.3 хувиар өсгөж 484, нийт төсөвт өртгийг 10,428.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 16,713.0 тэрбум төгрөг, харин 2025 онд санхүүжих дүнг 5,029.6 тэрбум төгрөгөөс 41.8 хувиар бууруулан 2,926.1 тэрбум төгрөгөөр баталжээ. Түүнчлэн тогтоол батлагдсаны дараа ТАХ-г багцлан задалснаар нийт ТАХ-ний тоо 996 болж нэмэгдсэн байна.

Дүрслэл 3. ТАХ /тоогоор/



Дүрслэл 4. ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжилтээр



1.3.6 НТАГ-аас шинээр хэрэгжүүлэх 1,884.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 98 ТАХ-ний 25.5 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй гэж дүгнэж, төсөвт тусгаж батлахгүй байх зөвлөмжийг НИТХ-ын дарга болон Нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн байна.



1.3.7 НИТХ-ын 2024 оны 24/33 дугаар тогтоолоор төсөвлөлтийн шаардлага хангаагүй дээрх 25 ТАХ-г хэвээр баталж, НТАГ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

1.3.8 НТАГ-аас Нийслэлийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын дүгнэлтээр 3 зөвлөмж, 49,240.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар):

- Төсвийн тухай хуульд тогтоомжид заасан төсөвлөлтийн шаардлага бүрэн хангасан ТАХ-г хөрөнгө оруулалтын төсөвт төлөвлөж батлуулах;
- ТАХ-ний худалдан авах ажиллагаа болон гүйцэтгэлийн шатанд гарсан зөрчлийг арилгаж, хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

“НХОГ” ОНӨААТҮГ:

- Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

1.3.9 Аудитаар илэрсэн зөрчлийн тоог өмнөх онтой харьцуулахад төсөвлөлтийн шаардлага хангаагүй болон гэрээний хэрэгжилттэй холбоотой зөрчлүүд нэмэгдэж, худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил буурсан байна.

1.3.10 Иймд төсөвлөлтийн шаардлага хангасан ТАХ-г төлөвлөөгүй, эрэмблээгүй, Төрийн аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.



БҮЛЭГ 2. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН БАЙНА.

2.1. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ-ний 46.5 хувь нь төлөвлөгөөнд тусгагдаагүй буюу нэмэлтээр хэрэгжсэн, 57.1 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

2.1.1 Төсвийн жилийн эхэнд Нийслэлийн харьяаны 11 байгууллага 274.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 184 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 22 байгууллага 12,014.3 тэрбум төгрөгийн 344 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

2.1.2 Худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн 184 ТАХ нь гүйцэтгэлийн шатанд 344 (87.0%) ТАХ болж нэмэгдсэн, төсөвт өртөг нь 11,739.6 тэрбум төгрөг буюу 43.7 дахин өссөн байна.

2.1.3 Төлөвлөсөн болон гүйцэтгэсэн худалдан авах ажиллагааны хооронд үүссэн зөрүү нь төсөвт удаа дараа тодотгол хийж шинээр нэмсэн болон батлагдсан ТАХ-г багцад задалж зохион байгуулснаас шалтгаалсан байна.

2.1.4 Нийслэлийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 274.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 184 ТАХ-г нягтлахад 57.1 хувь нь төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй байна.

2.2. Тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан зөрчил буурсан байна.

2.2.1 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 12,014.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 344 ТАХ-ний ХАА-г зохион байгуулжээ. Нийт тендерийн 40.1 хувийг ажил, 38.1 хувийг бараа, 11.3 хувийг үйлчилгээ, 2.6 хувийг зөвлөх үйлчилгээ тус тус эзэлж, 7.9 хувь нь хүчингүй болсон байна.

2.2.2 Нийслэлийн хэмжээнд 344 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахаар эрх шилжүүлсэнээс 287 нь буюу 83.4 хувь нь амжилттай зохион байгуулагдаж 106.4 тэрбум төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

2.2.3 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 342.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 74 ТАХ-ний худалдан авах ажиллагааг 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш зарласан байна. (Хавсралт 5)

2.2.4 Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан нийт ТАХ-ний 67.4 хувийг зураг төсөв, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл бүрэн шийдвэрлэгдээгүй байхад ажлын даалгавар болон загвар зурагт үндэслэн зарласан байна.

2.2.5 Ажлын даалгавраар тендер зарласантай холбоотойгоор 2025 онд шинээр хэрэгжүүлэх 1,301.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 34 ТАХ-ний зураг төсвийг гүйцэтгэлийн шатанд боловсруулж, зарим ТАХ-ний газрын зөвшөөрөл бүрэн шийдвэрлэгдээгүй байна. Тухайлбал:

- Сургуулийн барилга, 960 суудал (УБ, БГД, 25-р хороо/ барих 18,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- Тус бүр нь 6,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй БЗД, СХД-т гал түймэр унтраах аврах анги байгуулах ТАХ;
- Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (УБ, СХД 8 дугаар хороо) барих 3,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажил (УБ, СБД, 7 дугаар хороо) 1,139.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;



- *Нийслэлийн Өмчийн харилцааны газрын "Агуулах"-ын барилга (УБ) барих 864.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ.*

2.2.6 Энэ нь гэрээт ажил хугацаандаа эхлэхэд хүндрэл учруулж, хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг үүсгэж байна.

2.2.7 Худалдан авах ажиллагаа амжилттай зохион байгуулагдсан 287 ТАХ-ний 40 хувийг аудитын түүвэрт хамруулан нягтлахад 9 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг бүрэн хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна. *Тухайлбал:*

- **Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (2.2 тэрбум төг):** Шалгарсан ... ХХК нь тендерийн баримт бичгийн (ТШЗ 19.2) шаардлагыг бүрэн хангаагүй байна. Тухайлбал, ижил төстэй ажлын ажил хүлээлцсэн актгүй, туршлагыг нотлох баримт дутуу, ерөнхий инженер, талбайн инженер, ХАБЭА ажилтны НДШ төлөлтийн баримтгүй, ачааны машиныг өөрийн эзэмшлийнх байхаар шаардсан ч түрээсийн гэрээтэй байхад шалгаруулсан;
- **Бейсболын талбай шинээр байгуулах ажил (1,507.5 сая төг):** Шалгарсан ... ХХК нь тендерийн материал ирүүлэхдээ хүний нөөцийн туршлага болон НДШ-ийн төлөлт, техникийн хүчин чадал (ачааны автомашины даац)-ын шаардлагыг (ТШЗ 19.1.1, 19.1.2) хангаагүй, тухайн төсөл нь газрын зөвшөөрөлгүй, зураг төсөв болон магадлалын ерөнхий дүгнэлтгүй.

2.2.8 Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.9¹², 26.10¹³, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт болон СС-ын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан журмын 2.17¹⁴-д заасантай тус тус нийцээгүй байна.

2.2.9 Иймд худалдан авах ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг НИТХ болон НЗД-д хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

¹² 26.9.Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

¹³ 26.10.Энэ хуулийн 26.9-д зааснаас бусад тендер болон дараах тендерийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана;

¹⁴ 2.17.Хуулийн 45.2-т заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгаврыг ирүүлээгүй, илтэд алдаатай, эсхүл бүрэн бус ирүүлсэн бол мэргэжлийн байгууллага ажлын гурван өдрийн дотор захиалагчид мэдэгдэж, төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг холбогдох баримт бичиг бүрэн ирүүлэх хүртэл хугацаагаар зарлахыг түдгэлзүүлнэ.



БҮЛЭГ 3. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСНААР ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЕ ШАТАНД ЗУРАГ ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛЖ БАЙГАА НЬ ХЭРЭГЖИЛТЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА.

3.1 Хөрөнгө оруулалтын бодит гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байсны улмаас 65.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэлгүй олгосон байна.

3.1.1 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний санхүүжилтэд 2025 онд 2,926.1 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 69.5 хувийн санхүүжилт олгосон байна.

Дүрслэл 5. ТАХ-ний санхүүжилт



3.1.2 Хөрөнгө оруулалтын ТАХ болон санхүүжилтийн гүйцэтгэлийг тоо хэмжээгээр нь авч үзвэл 412 ТАХ-ний буюу 41.3 хувьд нь санхүүжилт олгогдоогүй байна.

3.1.3 Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа ТАХ-г шинээр хэрэгжүүлэх, шилжих болон он дамжих гэж ангилжээ. Үүнээс он дамжих ангилалд 9,617.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 406 ТАХ хамаарч, эдгээрийг өмнөх оны хөрөнгө оруулалтын төсвийн үлдэгдэл 395.3 тэрбум төгрөгөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

3.1.4 Хөрөнгө оруулалтын ТАХ-г төсөвт тусгахдаа шилжих, их засвар, арчлалт болон шинээр хэрэгжүүлэх гэсэн дарааллаар эрэмбэлэхээр заасан ч Нийслэлийн 2025 оны төсвийг батлахдаа шилжих ТАХ-г он дамжих болон шилжих гэж ангилж, ТАХ-ний санхүүжилтийг хоёр төсвийн жил дамжуулан хэрэгжүүлэхээр баталсан байна.

3.1.5 Дамжин хэрэгжихээр төлөвлөсөн 235 ТАХ-нд олгох санхүүжилтийн 49.8 хувийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5¹⁵ дахь заалт болон ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журмын 3.3.1¹⁶ дэх заалттай нийцээгүй байна.

3.1.6 Захиалагчийн хяналт хэрэгжиж буй 34 ТАХ-ний төсөвлөлтийн бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй (зураг төсөв магадлалаар баталгаажаагүй, газрын зөвшөөрөл болон газар чөлөөлөлт шийдвэрлэгдээгүй, байршил тодорхойгүй) нөхцөлд гүйцэтгэгчид 380.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Нийт санхүүжилтийн

¹⁵ 43.5-д заасныг зөрчиж “төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй”

¹⁶ 3.3.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн төсөлд тусгах төсөл, арга хэмжээг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална



84.5 хувь буюу 321.3 тэрбум төгрөгийг урьдчилгаа төлбөр хэлбэрээр олгожээ. (Хавсралт 6)

3.1.7 Холбогдох байгууллагууд гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс гэрээ сунгах хүсэлтийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй 14 ТАХ-ний гүйцэтгэгчээс 290.6 сая төгрөгийн алданги тооцож, төлүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна. (Хавсралт 7) Үүнд:

- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ: 11 ТАХ-ний гүйцэтгэгчээс 203.1 сая төгрөг;
- Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК: 1 ТАХ-ний гүйцэтгэгчээс 60.2 сая төгрөг;
- Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ: 2 ТАХ-ний гүйцэтгэгчээс 27.3 сая төгрөг.

3.1.8 Иймд нийт 290.6 сая төгрөгийн алдангийг нөхөн төлүүлж, төсвийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн актыг хариуцагч байгууллагуудад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.1.9 Мөн Хот байгуулалт, хотын стандартын газар захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байсан 3.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сэлбэ дэд төвийн орон сууцны барилгуудын суурийн холболтын зураг боловсруулах төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгосон боловч зураг төсөвт дахин өөрчлөлт оруулснаар өмнөх зураг ашиглалтгүй болж, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан байна.

3.1.10 Нийслэлийн төсвийн 2024-2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд (НИТХ-ын 24/33 тогтоол) “Албан хаагчдын орон сууц худалдан авах” зориулалтаар 15.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ТАХ-г баталж, НИТХ-ын 2025 оны 25/50 дугаар тогтоолоор уг төслийг хөрөнгө оруулалтын зардлаас хасаж, урсгал зардлын “Нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх арга хэмжээ” хөтөлбөрт шилжүүлсэн байна.

3.1.11 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.8, 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2, 35.11, 36 дугаар зүйлийн 36.1.1, 36.1.4-т заасныг үндэслэн НЗД нь 2025 оны захирамжуудаар нийт 147.9 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 48 ТАХ-г хэрэгжүүлэхээр Нийслэлийн харьяаны 8 байгууллага, хувийн хэвшлийн 11 аж, ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулах эрх олгосон байна.

Хүснэгт 5. Шууд гэрээ байгуулсан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн жагсаалт

№	Байгууллагын нэр	ТАХ-ний тоо	Гэрээний дүн (тэрбум төг)
1	Аж ахуйн нэгжүүд (ААН)	7	85.02
2	Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ	9	29.65
3	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ	19	14.54
4	Нийслэлийн баруун бүсийн зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ	2	7.25
5	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ	2	6.03
6	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ	1	2.65
7	Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ	6	1.25
8	Хилийн цэргийн 0119 дүгээр анги (ААТҮГ)	1	1.22
9	Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ	1	0.29
НИЙТ ДҮН		48	147.9

3.1.12 Дээрх ТАХ-нүүдийг хүний нөөцийн хүрэлцээгүй болон цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитын түүвэрт хамруулаагүй боловч дараагийн аудитаар үргэлжлүүлэн үзэх нь зүйтэй гэж үзлээ.

3.1.13 НЗД-ын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/972 тоот захирамжаар “Нийслэлийн баруун бүсийн зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-т “Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хороонд шинээр баригдах авто зам (СХД 34 дүгээр хороо)”, 528.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ, 2025 оны 08 дугаар сарын 06-



ны өдрийн А/1069 тоот захирамжаар Баялаг хотхоны авто замын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6 дугаар хороо), 311.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-г гүйцэтгэх эрхийг тус тус олгосон байна.

3.1.14 “Нийслэлийн баруун бүсийн зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ нь дээрх 2 ТАХ-г Суфа конбини ХХК, Баруун урт констракшн ХХК-аар туслан гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулахдаа нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “улс, орон нутгийн төсөв болон захилагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө”, 41 дүгээр зүйлийн 41.1-д “Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна” гэж заасантай тус тус нийцээгүй тул уг асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

3.2 ТАХ-г төсөвлөлтийн шаардлага хангаагүй баталсны улмаас гүйцэтгэлийн явцад зураг төсөв боловсруулах, газар чөлөөлөх зэрэг нэмэлт ажлууд хийгдэж, нийт гэрээний 62.9 хувь нь хугацаа хоцорсон байна.

3.2.1 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 7,784.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 813 ТАХ-ний гүйцэтгэлд Нийслэлийн харьяа 19 байгууллага захиалагчийн хяналт хэрэгжүүлж байна. Нийт ТАХ-ний 34.8 хувийг шинээр хэрэгжүүлэх, 65.2 хувийг өмнөх оноос шилжин хэрэгжих ТАХ эзэлж байна.

Хүснэгт 6. Гэрээ байгуулагдсан ТАХ (тэрбум төгрөг)

Хамрах огноо	Тоо	Гэрээний дүн
Он дамжих	297	727.1
Шилжих	233	3,502.7
Шинэ	283	3,554.4
Нийт	813	7,784.2

3.2.2 Хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгжилтийг явцаар нь авч үзвэл 59.7 хувь нь бүрэн дууссан, 36.9 хувь нь хугацаа болоогүй, 3.4 хувь нь гэрээ цуцлагдсан болон ажил нь удааширсан байна.

Хүснэгт 7. ТАХ-ний гэрээний хэрэгжилт (тэрбум төгрөг)

№	Гэрээний төлөв байдал	Төслийн тоо	Төсөвт өртөг	Эзлэх хувь
1	Хэрэгжиж дууссан	485	1,547.2	59.7
2	Хэрэгжиж байгаа	300	6,073.6	36.9
3	Зогссон болон цуцлагдсан	28	163.4	3.4
	Нийт	813	7,784.2	100.0


3.2.3 НЗДТГ болон түүний харьяа 19 байгууллагын хэмжээнд нийт 7,784.2 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 813 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлснээс 1,547.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий 485 ТАХ хэрэгжиж дууссан байна.

3.2.4 Захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллагуудын оролцоог ТАХ-ний тоо болон санхүүжилтийн дүнгээр харьцуулан үзвэл:

- **ТАХ-ний тоогоор:** Нийт төслийн хамгийн их буюу 45.1 хувийг НХОГ ОНӨААТҮГ, 29.1 хувийг НЗХГ, 10.8 хувийг НЭМГ хариуцаж байна.
- **Гэрээний үнийн дүнгээр:** Нийслэлийн Замын хөгжлийн газар хамгийн өндөр буюу 3,237.3 тэрбум төгрөгийн (41.5%) төсөлд хяналт тавьж байгаа бол Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК 1,874.6 тэрбум төгрөг (23.8%), Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ 1,654.5 тэрбум төгрөгийн (21.0%) ТАХ-г тус тус хариуцаж байна.



Дүрслэл 6. Захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллагуудын ТАХ, санхүүжилтийн эзлэх хувь




3.2.5 Дээрх үзүүлэлтээс харахад захиалагчийн хяналтын үндсэн ачаалал болон санхүүжилтийн дийлэнх хэсэг буюу 86.3 хувь нь Нийслэлийн Замын хөгжлийн газар, Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК болон “НХОГ” ОНӨААТҮГ-т төвлөрч байна.

3.2.6 Харин Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба 290.1 тэрбум төгрөг буюу нийт санхүүжилтийн 3.7 хувьтай тэнцэх ТАХ-нд хяналт тавьж ажилласан байна.

3.2.7 Нийт ТАХ-ний 37.0 хувь нь гэрээний хугацаанд хэрэгжсэн бол 63.0 хувь нь анхны гэрээний хугацааг 2-10 удаа сунгасан байна.

Дүрслэл 7. Гэрээний сунгалт



3.2.8 Аудитын түүвэрт нийт ТАХ-ний 32.02 хувь буюу 270 төслийг хамруулан шалгахад, тэдгээрийн 44.1 хувьд нь зөрчил илэрлээ. Үүнд:

3.2.9 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу зураг төсөвгүй, магадлалын дүгнэлтийн хугацаа дууссан, газрын асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй 1,491.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 75 ТАХ-г эхлүүлснээс шалтгаалан ажлын явц удааширч, хугацаа алдах нөхцөл бүрджээ. (Хавсралт 8) Тухайлбал:

- Эмзэлт эко аж үйлдвэрийн паркийн дулааны цахилгаан станц, бохир ус цэвэрлэх байгууламж: Гэрээний дүн 224.6 тэрбум төгрөг, хоёр байгууламжийн зураг төсөл боловсруулах шатандаа байгаа бөгөөд ажлын явц 20.0 хувьтай;
- Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хорооны цогцолбор барилга (Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсэг): Гэрээний дүн 2.97 тэрбум төгрөг, газрын асуудал шийдэгдээгүй, архитектор төлөвлөлтийн даалгавар гараагүйгээс ажил зогсонги байдалд орж, гүйцэтгэл 5.0 хувьтай;



- Нийслэлийн Өмчийн харилцааны газрын "Агуулах"-ын барилга: Гэрээний дүн 0.79 тэрбум төгрөг, зураг төсөвгүй ажлын даалгавраар зарлагдсан ажлын явц 5.0 хувь;
- Шалган нэвтрүүлэх товчооны байр: Гэрээний дүн 0.89 тэрбум төгрөг, зураг төсөл нь магадлалаар баталгаажгаагүйгээс гүйцэтгэл 5.0 хувь;
- Эсгийлэх дэд станцын зураг төсөв: Гэрээний дүн 0.15 тэрбум төгрөг, дэд станцын газрын асуудал шийдвэрлэгдээгүй ажлын явц 5.0 хувь;
- Баянгол дүүргийн 25 дугаар хорооны 960 суудлын сургуулийн барилга: Гэрээний дүн 16.6 тэрбум төгрөг, газрын асуудал шийдэгдээгүй, зураг төсөвгүй ажлын даалгавраар батлагдсан ажил эхлэлтийн шатандаа буюу 5.0 хувь;
- Хан-Уул дүүргийн 18 дугаар хорооны 640 суудлын сургуулийн барилга: Гэрээний дүн 9.3 тэрбум төгрөг, газрын асуудал шийдэгдээгүй, ажлын зураг боловсруулах шатанд буюу 5.0 хувь;
- Баянзүрх дүүргийн 2, 4 дүгээр хорооны инженерийн шугам сүлжээний ажил: Гэрээний дүн 6.5 тэрбум төгрөг, ажлын зураг боловсруулах шатандаа байгаагаас шалтгаалан гүйцэтгэл 10.0 хувьтай байна.

3.2.10 Гүйцэтгэгчийн хариуцлагагүй байдлаас шалтгаалан нийт 144.3 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 19 ТАХ үргэлжлэх боломжгүйд хүрч, гэрээ цуцлагдсан байна. Үүнээс 5 ТАХ-ний хүрээнд бодит ажил хийгдээгүй байхад гүйцэтгэгчид 2.9 тэрбум төгрөгийн явцын санхүүжилт олгож, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан байна. Тухайлбал:

- Улаанбаатар хотын бохир усны "Туул-1" коллекторын барилга угсралт: Гэрээний дүн 6.19 тэрбум төгрөг, бодит ажил хийгдээгүй байхад 1.9 тэрбум төгрөг;
- Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны инженерийн шугам сүлжээний зураг төсөл: Гэрээний дүн 0.099 тэрбум төгрөг, бодит ажил хийгдээгүй байхад 0.029 тэрбум төгрөг;
- Гэр хорооллын дахин зохион байгуулалтын зураг төсөл: Гэрээний дүн 0.098 тэрбум төгрөг, бодит ажил хийгдээгүй байхад 0.029 тэрбум төгрөг;
- Гандантэгчлэн хийд орчмын инженерийн дэд бүтцийн ажил: Гэрээний дүн 0.741 тэрбум төгрөг, бодит ажил хийгдээгүй байхад 0.589 тэрбум төгрөг;
- "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын автобус паркийн барилга: Гэрээний дүн 4.34 тэрбум төгрөг, бодит ажил хийгдээгүй байхад 0.250 тэрбум төгрөг.

3.2.11 Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлснээс шалтгаалан 14 ТАХ-ний гэрээний хугацаа хэтэрч, нийт 290.6 сая төгрөгийн алданги тооцох үндэслэл бүрдсэн боловч холбогдох арга хэмжээг аваагүй байна. Тухайлбал:

- Цэцэрлэгийн барилга, 150 ор (Баянгол дүүрэг, 11 дүгээр хороо, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн цэцэрлэг) гүйцэтгэгч Тэргүүн констракшн ХХК: Гэрээний дүн 4,259.7 сая төгрөг, тооцогдох 85.0 сая төгрөг;
- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Хан-Уул дүүрэг, 9 дүгээр хороо/ гүйцэтгэгч Шунхлайн шандас ХХК: Гэрээний дүн 6,456.6 сая төгрөг, тооцогдох 20.9 сая төгрөг;
- Гэр хорооллын дахин зохион байгуулалтын зураг төслийн ажил/ гүйцэтгэгч Цолмон Арт болон тэгшхэм групп ХХК: Гэрээний дүн 98.0 сая төгрөг, тооцогдох 16.6 сая төгрөг;
- Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 8 дугаар хороо/ гүйцэтгэгч Жинст цамхаг ХХК: Гэрээний дүн 6,259.0 сая төгрөг, тооцогдох 23.4 сая төгрөг;
- Сэлбэ дэд төвийн Орон сууцны хорооллын барилгажилтын төслийн нэг маягийн орон сууцны барилгуудын холболт, ХТП, РП-ийн барилгуудын суурийн холболтын зураг төсөл боловсруулах: Гэрээний дүн 2,231.7 сая төгрөг, тооцогдох 60.2 сая төгрөг;
- Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 37 дугаар хороо): Гэрээний дүн 4,776.0 сая төгрөг, тооцогдох 11.3 сая төгрөг;
- Дүүргийн эрүүл мэндийн төвийн барилгын их засвар-2 (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 13 дугаар хороо): Гэрээний дүн 4,369.0 сая төгрөг, тооцогдох 15.8 сая төгрөг.

3.2.12 Захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллагуудын ТАХ-ний гүйцэтгэлийг түүврээр шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ:

3.2.13. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 1,654.5 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 379 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн бөгөөд 19 ТАХ-ний хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. (Хавсралт 10) Тухайлбал:

Алслагдсан дүүрэг дэх төслүүдийн зөрчил:

- Соёлын ордны барилга (Багахангай, 5.15 тэрбум төг): Ажил зогссон байхад гэрээ дүгнэж, алданги тооцолгүй хугацаа сунгаасан, магадлалгүй зургаар дахин гүйцэтгэгч сонгосон;



- Гэр хорооллын тохижилт (БНД, 0.21 тэрбум төг): Гүйцэтгэгч ажлаа орхиж, тоноглолууд эвдэрсэн байхад хариуцлага тооцолгүй гэрээг үндэслэлгүй сунгасан;

Зүүн бүс дэх төслүүдийн зөрчил:

- Цогцолбор барилга (БЗД, 35-р хороо, 3.69 тэрбум төг): Магадлалын дүгнэлтгүй ажил эхлүүлсэн, зураг төсөлд өөрчлөлт орсон, гэрээ сунгах хүсэлтийг хугацаа хоцроож өгсөн;
- Эрүүл мэндийн төв (БЗД, 24-р хороо, 9.9 тэрбум төг): Зураг төсөлд өөрчлөлт орсон, гүйцэтгэгч гэрээ сунгах хүсэлтийг хугацаандаа ирүүлээгүй;

Баруун бүс дэх төслүүдийн зөрчил:

- 150 ортой цэцэрлэг (БГД, 11-р хороо, 4.26 тэрбум төг): Магадлалгүй ажил эхлүүлсэн, гадна тохижилт, зам талбайн ажил хийгдээгүй байхад гүйцэтгэл давуулж санхүүжилт олгосон, гэрээний хугацааг албан ёсоор сунгаагүй;
- Автобусны гарааш (Багц-1, 4.66 тэрбум төг): Гэрээ сунгах хүсэлтийг хугацаанд нь ирүүлээгүй, хугацаа хэтэрсэн боловч гэрээний дагуу алданги тооцоогүй;

Төвийн бүс дэх төслүүдийн зөрчил:

- Чингэлтэй дүүргийн Нутгийн захиргааны байр (64.8 тэрбум төг): Газар чөлөөлт дуусаагүй, барилга эхлүүлэх зөвшөөрөлгүй байхад ажлыг эхлүүлсэн;
- Урт цагаан, Жуулчны гудамжны тохижилт (38.9 тэрбум төг): Гэрээ сунгах хүсэлтийг хугацаанд нь ирүүлээгүй, гэрээний дагуу тооцогдох алдангийг төлүүлээгүй;
- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (ХУД, 9-р хороо, 6.45 тэрбум төг): Гэрээ сунгах хүсэлтийг хугацаа хоцроож ирүүлсэн, гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийг тооцоогүй.

Сонгинохайрхан дүүргийн барилга Захиалагчийн алба ОНӨААТҮГ:

3.2.14 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 57.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 13 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлэн ажиллажээ. Шалгалтаар тус байгууллагын хариуцсан 5 ТАХ-тэй холбоотой гэрээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж, холбогдох хууль, журам зөрчин ажил эхлүүлсэн, гэрээний хугацаа хэтрэлтэд хяналт тавиагүйн улмаас тооцвол зохих алдангийг гүйцэтгэгчээр төвлөрүүлээгүй, төсвийн орлого бүрдүүлэх боломжийг алдсан байна. Үүнд:

- Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (СХД, 33 дугаар хороо, 4.67 тэрбум төгрөг): төсөвт өртөг бүхий угсралтын ажлыг ажил эхлүүлэх зөвшөөрөлгүй, зураг төсөв нь магадлалаар баталгаажаагүй байхад эхлүүлсэн, хийгдээгүй ажлыг гүйцэтгэсэн мэтээр хуурамч материал бүрдүүлж, бодит гүйцэтгэлээс давуулан гүйцэтгэл бичсэн, ажлын даалгавар шинэчлэгдсэн гэж байгаа ч баримтаар нотлогдоогүй;
- Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (СХД, 37 дугаар хороо, 4.78 тэрбум төгрөг): Зураг төсвийн магадлалын дүгнэлт гараагүй байхад ажил эхлүүлж, санхүүжилт олгосон, гэрээний хугацаа дууссаны дараа ирүүлсэн сунгах хүсэлтэд алданги тооцоогүй, гүйцэтгэл давуулж санхүүжилт олгосон;
- Дүүргийн эрүүл мэндийн төвийн барилгын их засвар-2 (СХД, 13 дугаар хороо, 4.37 тэрбум төгрөг): Зураг төслийн магадлалын дүгнэлтийн хүчинтэй хугацаа дууссан байхад ажил гүйцэтгэсэн бөгөөд гэрээний хугацаа хэтэрсэн асуудалд алданги тооцолгүйгээр гэрээг сунгасан, захиалагч байгууллага магадлалыг шинэчлэн хийлгэх хяналтын үүргээ хэрэгжүүлээгүй;
- Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (СХД, 35 дугаар хороо, 5.2 тэрбум төгрөг): Холбогдох хууль журамд заасан ажил эхлүүлэх зөвшөөрөл аваагүй байхад барилга угсралтын ажлыг эхлүүлсэн;
- Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар (СХД, 13 дугаар хороо, 4.36 тэрбум төгрөг): гэрээний хугацаа дууссаны дараа ирүүлсэн сунгах хүсэлтэд алданги тооцоогүй.

“Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК:

3.2.15 Нийслэлийн үнэт цаасны (бонд) санхүүжилтээр нийт 1,874.6 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 14 багц ТАХ хэрэгжиж байгаагаас зураг төсөл, зөвлөх үйлчилгээний 2.7 тэрбум төгрөгийн 2 ТАХ, гадна инженерийн шугам сүлжээний 14.2 тэрбум төгрөгийн 5 ТАХ, орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын 1,857.6 тэрбум төгрөгийн 7 ТАХ тус тус хэрэгжиж байна.

3.2.16 Төслийн хүрээнд 158 га талбайд дэд бүтэц, сургууль, цэцэрлэг болон үйлчилгээний цогцолбор бүхий 113 блок, 8575 айлын орон сууцны хорооллыг карказ



болон бүрэн цутгамал хийцээр барихаар төлөвлөжээ. Төслийн гүйцэтгэлд хийсэн шалгалтаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Орон сууцны хорооллын БАГЦ-1 (373.3 тэрбум төг) төслийн зураг төсөв магадлалаар баталгаажуулаагүй байхад барилга угсралтын ажлын гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн;
- Орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын БАГЦ-2 (448.7 тэрбум төг) төсөлд барилгажуулахаар төлөвлөсөн 158 га талбайн газар чөлөөлөлт бүрэн дуусаагүй, иргэдтэй тохиролцоо хийгдээгүй байхад барилга угсралтын ажлыг эхлүүлсэн;
- Барилгын талбайд хөтлөгдөх улаан журналын хөтлөлтөд үзлэг хийхэд нийт 67 блокоос 8 блокын журналд тэмдэглэгээ хийгдсэн байна. Үлдсэн 59 дэвтэрт буюу нийт журналын 88.05 хувьд ямар нэгэн тэмдэглэгээ хийгдээгүй;
- Зураг төсөл боловсруулах 2.23 тэрбум төгрөгийн төслийн хүрээнд гүйцэтгэгчээс хүлээлгэн өгсөн зураг төсөв алдаатай, гэрээний үүрэг дутуу байхад захиалагч байгууллага зөрчлийг залруулах, сайжруулах талаар шаардлагатай арга хэмжээ аваагүй;
- Орон сууцны хорооллын барилгажилтын төслийн (2.2 тэрбум төг) нэг маягийн орон сууцны барилгуудын холболт, ХТГ, РП-ийн барилгуудын суурийн холболтын зураг зураг боловсруулах гэрээт ажлын хугацаа 21 хоногээр хэтэрсэн, 60.2 сая төгрөгийн алдангийг гүйцэтгэгчээс төлүүлж аваагүй;
- "Сэлбэ дэд төв" орчмын гэр хорооллын дахин төлөвлөн орон сууцжуулах ажлын ТЭЗҮ, зураг төсөл, зөвлөх үйлчилгээ боловсруулах ажлын нэмэлт гэрээ (Улаанбаатар хот), Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол БАГЦ-1 Гадна цахилгаан, холбоо дохиолол, гэрэлтүүлэг, дэд өртөө, РП-ний (5,966.1 тэрбум төг) барилга угсралтын ажил, /10.3га/. Тус 2 гэрээт ажлын гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих үүрэг хангалтгүй хэрэгжүүлснээс гүйцэтгэгчид алданга тооцож, төсөвт хөрөнгө төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Нийслэлийн Замын хөгжлийн газар:

3.2.17 Тус газар нь 2 ТАХ-ний магадлалын дүгнэлт баталгаажуулаагүй байхад авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, зөвшөөрөл олгосон байна. Үүнд:

- Баянзүрх дүүргийн 37 дугаар хорооны 1.7 км авто замын барилга байгууламжийн Багц-2 (4,156.3 сая төг) ТАХ-ний зураг төсөв магадлалаар баталгаажуулаагүй (2025.09.04) байхад ажил эхлүүлэх зөвшөөрөл (2025.05.23) олгож, ажлыг эхлүүлсэн;
- Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хорооны Хуурай мухрын гал унтраах ангийн цогцолбор барилгын авто замын (462.5 сая төг) ТАХ-ний зураг төсөв магадлалаар баталгаажуулаагүй (2025.06.09) байхад ажил эхлүүлэх зөвшөөрөл (2025.06.06) олгож, ажлыг эхлүүлсэн байна.

3.2.18 Эдгээр нь Барилгын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5¹⁷, Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.5¹⁸, "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.16¹⁹, "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам"-ын 2.2²⁰-т заасантай тус тус нийцээгүй байна.

3.2.19 Иймд төсөл, арга хэмжээг хууль, журам зөрчиж ажил эхлүүлсэн, гэрээний хяналт болон баримт бичгийн бүрдлийг хангаагүй алдаа зөрчил гаргасан байгууллагуудын буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба:

3.2.20 Нийт 290.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 11 ТАХ-нд хяналт тавьж ажилласнаас газар чөлөөлөлтөд 288.2 тэрбум төгрөг, эд хөрөнгийн үнэлгээнд 1.56 тэрбум төгрөг, барилга буулгах ажилд 0.28 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ багтаж байна.

¹⁷ 28.5 "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргасан этгээдийн хүсэлтэд хавсаргасан энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгийг хянан шийдвэрлэж, Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаагаар зөвшөөрөл олгоно",

¹⁸ 222.5-д "Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь хугацаа хэтрүүлснээс учруулсан хохирлыг хариуцна", 232 дугаар зүйлийн 232.6-д "Хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлөх үүрэгтэй",

¹⁹ 3.16.Барилгын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, чанаргүй, дутуу гүйцэтгэсэн, захиалагч болон эрх бүхий байгууллагын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахгүй. Энэ тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон хөрөнгө оруулагч санхүүжилт олгохгүй байж болно.

²⁰ 2.2 "Захиалагч авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан баримт бичгийн бүрдэл шаардлага хангаж байгаа эсэхийг хянаж, шийдвэрлэнэ."



3.2.21 Бүтээн байгуулалтын ажлын нөлөөлөлд өртсөн 1329 иргэн, аж ахуйн нэгжийн газар болон хөрөнгийн нөхөн олговорт нийт 288.2 тэрбум төгрөгийг олгосон байна.

Хүснэгт 8. Газар чөлөөлсөн талбайн ашиглалт (Ажлын явцаар)

№	Бүтээн байгуулалтын чиглэл	Нийт	Үүнээс газар чөлөөлөлт дуусаж, бүтээн байгуулалтын ажил		
			Эхэлсэн	Эхлээгүй	Тодорхойгүй
1	Барилга байгууламж (Орон сууц, Сургууль г.м)	815	473	237	105
2	Авто зам, зогсоол, нүхэн гарц	274	202	12	60
3	Тохижилт, шугам сүлжээ	108	90	16	2
4	Үер, халиа дошны хамгаалалт	92	0	92	0
5	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон бусад	40	3	35	2
Нийт дүн		1329	768	392	169

3.2.22 Газар чөлөөлөлт хийгдэх нийт 1,329 нэгж талбарын 57.8 хувьд нь бүтээн байгуулалтын ажил эхэлсэн, 29.5 хувьд нь ажил эхлээгүй байна.

3.2.23 Нөхөн олговортойгоор газар чөлөөлсөн 200 иргэн, аж ахуйн нэгжийн газрын шилжилт хөдөлгөөнийг 2025 онд хийж, 99 этгээдэд үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ шинээр олгосон байна. Газар чөлөөлөлтийн явцад өмчлөх эрхийг баталгаажуулсан болон зохих зөвшөөрөлгүй баригдсан барилгад нөхөн олговор олгосон нь төсвийн зардал өсөх үндсэн шалтгаан болсон байна. **Тухайлбал:**

- Иргэн Л.Ч: 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр 1.4 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгосон. Шалгалтаар тухайн иргэн архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг, инженер-геологийн дүгнэлт болон барилга эхлүүлэх зөвшөөрөлгүйгээр барилгын карказ босгосон байхад холбогдох байгууллагууд хяналтын арга хэмжээ авалгүйгээр нөхөн олговрыг тооцож олгосон;
- Иргэн М.М: “Улаанбаатар Арена спорт цогцолбор” барих төслийн нөлөөлөлд өртсөн тухайн иргэнд нийт 1.5 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгосон. Ингэхдээ 280 м.кв өмчилсөн газарт 315.3 сая төгрөг, 700 м.кв газарт 1.2 тэрбум төгрөгийг тус тус тооцсон байна. Гэвч өмчлөх эрхийн гэрчилгээг нөхөн олговор олгох шийдвэр гарснаас хойш буюу 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр шинээр олгосон байна.

3.2.24 Дээрх зөрчил нь Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4²¹ ЗГ-ын 2024 оны 91 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам”-ын 13.3²²-д заасантай нийцээгүй байна.

3.2.25 Иймд холбогдох хууль тогтоомжийг мөрдөөгүй, газар чөлөөлөх явцад газрын эрхийн шилжилт хөдөлгөөнд хяналт сул тавьснаас нөхөн олговрын төсвийг нэмэгдүүлсэн буруутай албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.3. Хэрэгжиж дууссан ТАХ-ний 49.1 хувийг өмчийн бүртгэлд тусгасан, барилга угсралт, зураг төслийн ажлууд төлөвлөлтийн алдаанаас шалтгаалж удаашралтай байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй нийт 813 ТАХ-ний 1,540.6 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 485 ТАХ буюу 59.6 хувь бүрэн хэрэгжиж дууссан байна.

Хүснэгт 9. ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийг өмчийн бүртгэлд тусгасан байдал

№	Ангилал	Нийт ТАХ		Үүнээс өмчид бүртгээгүй ТАХ	
		Тоо	Гэрээний дүн (тэрбум.төг)	Тоо	Гэрээний дүн (тэрбум.төг)

²¹ 37.4.Энэ хуулийн 37.2-т заасан мэдэгдлийг хүлээж авснаас хойш барьж байгуулсан үл хөдлөх эд хөрөнгө, газрын үнийг мэдэгдэхүйц өсгөсөн бусад арга хэмжээний зардлыг нөхөн олгохгүй.

²² 13.3 Газрыг зохих зөвшөөрөлгүй дур мэдэн эзэмшсэн, зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэж, Газрын тухай хуулийн 57.3, 57.4, 57.5, Барилгын тухай хуулийн 35.1.7, Хот байгуулалтын тухай хуулийн 9.2-т заасан арга хэмжээг авна.



1	Барилга, байгууламж	117	705.7	51	190.6
2	Газар чөлөөлөлт	11	290.1	11	290.1
3	Их засвар	174	303.3	127	233.4
4	Тоног төхөөрөмж	148	154.2	19	37.0
5	ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	35	87.2	30	30.9
Нийт		485	1,540.6	238	782.1

3.3.1 Нийт 1,540.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын 50.8 хувь буюу 782.1 тэрбум төгрөг өмчид бүртгэгдээгүй, үүний газар чөлөөлөлтийн 290.1 тэрбум төгрөг, их засварын ажлын 76.9 хувь, ТЭЗҮ болон зураг төслийн зардлын 85.7 хувийг эзэлж байна.

3.3.2 ТАХ-г өмч бүртгэлд тусгаагүй нь хариуцагч байгууллагын хариуцлагагүй байдал (52.5%), хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төлөвлөлт (26.9%), эцсийн санхүүжилт олгогдоогүй (15.1%), ашиглалтад хүлээн авах улсын комиссын акт баталгаажгаагүй (5.5%) зэрэг шалтгаанууд тус тус нөлөөлжээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай, өмчид бүртгэх боломжгүй ТАХ-г баталсан.

Тухайлбал:

- Алсын зайн мэдрэгчтэй угаарын хий мэдрэгчийг суурилуулах ажил (Улаанбаатар хот) 7.65 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1 ТАХ;
- Алсын зайн дамжуулагчтай угаарын болон хийн түлшний мэдрэгч (Улаанбаатар хот) 15.9 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 2 ТАХ;
- Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтөд ороогүй айл өрхүүдийн ашиглалтын шаардлага хангасан зуух (Улаанбаатар хот) 27.3 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1 ТАХ;
- Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй ТАХ-ний газар чөлөөлөлт, нөхөн олговор (Улаанбаатар хот) 269.9 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1 ТАХ;
- БЗД, БНД, БХД, Налайх "Нийслэлд хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын ТАХ-ний нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн эртгээдийн газар, эд хөрөнгийн үнэлгээ хийх" 0.35 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1 ТАХ;
- Шинэ их тойруу-баян бүрд орчмын газар чөлөөлөлт, нөхөн олговор (Улаанбаатар хот) 18.08 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1 ТАХ;
- Боловсрол цогцолбор сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны гадна фасад засварын ажил (Улаанбаатар хот, БНД, 3 дугаар хороо) 1.5 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1 ТАХ;
- Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, СБД) Голомт хотхоны фасад 5 байр /2,4,6,32а, 39а/ Багц-4 2.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1 ТАХ.

3.3.3 Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ТАХ-ний хүрээнд нийт 12.9 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 19 ТАХ-ний зургийг "барилга угсралтын явцад өөрчлөгддөг" гэх үндэслэлээр өмчийн бүртгэлд тусгаагүй байна. Тухайлбал:

- Нийслэлийн авто зам, замын байгууламжийн бүртгэл, мэдээллийн сангийн хөгжүүлэлт: 3.17 тэрбум төгрөгийн өртөгтэй;
- "Шинэ тойрог зам"-ын хойд хэсэг (55 км замын ТЭЗҮ): Улаанбаатар-Дархан чиглэлээс Баянзүрхийн гүүр хүртэлх болон босоо чиглэлийн авто замуудын ТЭЗҮ боловсруулах 1.96 тэрбум төгрөгийн өртөгтэй;
- Эмээлт эко аж үйлдвэрийн парк - Шувуун фабрик чиглэлийн Туул голын гүүр: 0.43 тэрбум төгрөгийн өртөгтэй;
- Их Монгол Улсын гудамжнаас Зайсангийн гудамж хүртэлх замын ангилал дээшлүүлэх ажил: 0.51 тэрбум төгрөгийн өртөгтэй.

3.3.4 Дээрх ТАХ-ний үр дүнд бий болсон зураг төсвүүдийг "барилгын явцад өөрчлөгддөг" гэх шалтгаанаар өмчид бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг зөрчиж, төсвийн хөрөнгөөр бий болсон биет бус хөрөнгийг үнэгүйдүүлэх, бүртгэлээс гадуур орхисон байна.



3.3.5 ТЭЗҮ болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ боловсруулах 87.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий 35 ТАХ-ний үр дүнд бий болсон баримт бичгийг бүртгэх эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас шалтгаалан өмчийн бүртгэлд тусгаагүй байна.

3.3.6 Иймд төсвийн хөрөнгөөр бий болсон биет бус хөрөнгийг бүртгээгүй 12.9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулахаар НЗХГ-т албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

3.3.7 Тоног төхөөрөмж нийлүүлэх 4 ТАХ-ний хүрээнд бий болсон 50.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий 189,000 ширхэг хөрөнгийг Нийслэлийн төвийн 6 дүүрэг болон Налайх дүүргийн “Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” өмчид бүртгэсний дараа иргэдэд үнэ төлбөргүй тараасан байна.

Хүснэгт 10. Тоног төхөөрөмж нийлүүлэлт, өмчийн бүртгэлийн байдал (тэрбум төгрөг)

№	Тоног төхөөрөмжийн нэр	Гэрээний дүн	Тоо, ширхэг	Иргэдэд тараасан огноо	Өмчид бүртгэсэн огноо
1	Стандартад нийцсэн давхар шаталттай зуух	27.36	32,000	2025 оны 11, 12 дугаар сар	2025.12.18
2	Алсын зайн дамжуулагчтай угаарын болон хийн түлшний мэдрэгч	6.75	45,000	2025 оны 4, 9, 12 дугаар сар	2025.12.18
3	Угаарын хий мэдрэгч (нэмэлт багц 1)	7.65	51,000	2025 он	2025.05.21
4	Угаарын хий мэдрэгч (нэмэлт багц 2)	9.15	61,000	2025 он	2025.12.02
Нийт дүн		50.91	189,000		

3.3.8 Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2²³, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1²⁴ дэх заалтыг зөрчсөн байна.

3.3.9 Тайлант онд их засвар, тоног төхөөрөмж нийлүүлэлт болон газар чөлөөлөлтийн ажил 84.5-91.7 хувийн өндөр гүйцэтгэлтэй байгаа бол бүтээн байгуулалтын үндсэн суурь болох барилга угсралт, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлын хэрэгжилт 28.7-38.0 хувьтай байна.

Дүрслэл 8. ТАХ-ний хэрэгжилт тоогоор



3.3.10 Дүрслэлээс харахад богино хугацааны шинжтэй ажлууд эрчимтэй хийгдэж байгаа ч томоохон бүтээн байгуулалтын ТАХ-г төлөвлөлтийн шатанд зураг төсөв, магадлалын асуудлыг бүрэн шийдвэрлээгүй баталснаас үүдэн гүйцэтгэлийн шатанд ажил зогсох, хугацаа сунгах нөхцөлийг бүрдүүлж байна.

3.3.11 Тайлант хугацаанд нийт 705.7 тэрбум төгрөгийн өртөг бүхий барилга байгууламж барих 117 ТАХ хэрэгжсэнээс 43 сургууль, цэцэрлэг (36.7%), 35 инженерийн

²³ 16.5.2 батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих

²⁴ 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.



шугам сүлжээ (29.9%), 23 тохижилт (19.7%), 13 авто зам (11.1%) болон төрийн байгууллагын 4 барилга (2.6%) тус тус эзэлж байна.

3.3.12 Мөн 303.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий их засварын ажлын 51.7 хувийг авто зам засвар, арчлалт, 14.9 хувийг инженерийн шугам сүлжээ, 13.8 хувийг орон сууцны дээвэр, фасад, 6.3 хувийг төрийн байгууллагын байр болон лифт засварын ажил тус тус эзэлж байна.

3.3.13 Тайлант хугацаанд барилга байгууламжийн ажилд зарцуулсан нийт хөрөнгийн 50.4 хувийг инженерийн шугам сүлжээ, 27.5 хувийг сургууль, цэцэрлэг болон нийгмийн салбарын барилга, 11.2 хувийг тохижилт, 9.2 хувийг газар чөлөөлөлт, үлдсэн 1.5 хувийг төрийн байгууллагын оффисын барилга барихад тус тус зарцуулжээ.

3.3.14 Дээрх аудитаар 3 орон нутгийн өмчит аж ахуй нэгж байгууллагаас 290.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, алдаа зөрчил гаргасан холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ноогдуулах 4 албан шаардлагыг тус тус хүргүүлж, 1 ОНӨААТҮГ-ыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, НИТХ-ын даргад 2, НЗД-д 5 зөвлөмж хүргүүлж ажиллалаа.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ




**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР**
Хөвсгөл лэйк сити төвөр-8/1, Багатайруу 1,
8 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14200
Утас/Факс: (976-11) 32 02 48
Цахим хуудас: www.umch.ub.gov.mn

2026.05.08 № 1/802
танай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

"Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд саналгүй болно.

 Нийслэлийн өмчийн харилцааны газар
Захиргаа
Дарга
Володя Оюумаа
2026.05.11 09:15

1426030048



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2026.05.11 № 03/3103
танай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

Нийслэл дэх Төрийн аудитын газраас "Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Хавсралтаар хүргүүлж байгаа тайлбар, саналтай танилцаж, тайлангийн төслийн холбогдох хэсэгт саналыг тусган, өөрчлөлт оруулж өгнө үү.

Хавсралт хуудастай.

ДАРГА



Т.ОЮУНЧИМЭГ

C:\Users\DELL\2026 он\ITГ-A5\ITГ-A5.docx
1726192123



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР**
Хотын захиргааны төв цогцолбор Б байр,
Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 53 85
Цахим шуудан: info@road.ub.gov.mn
Цахим хуудас: www.road.ub.gov.mn


2026.05.12 № 02/2068
танай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАРТ

"Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Нийслэлийн Замын хөгжлийн газраас санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 12 хуудастай.

 Замын хөгжлийн газар
Удирдлага
Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Батсайхан Одбаяр
2026.05.12 16:02



**НИЙСЛЭЛИЙН
"ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР"
ОНОЛААГУУ**
Наадамчдын зам 1201, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100, Утас: (976-11) 31 16 32
Цахим хуудас: nhog@invest.ub.gov.mn
Цахим хуудас: www.invest.ub.gov.mn


2026.05.13 № 01/2316
танай 2026.05.06 -ны № 05-03/2851 -т

Хариу хүргүүлэх тухай

Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хийсэн Аудитын тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох тайлбарыг хүргүүлж байна.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгчийн зүгээс тус тайланд дурдагдсан төсөл, арга хэмжээнүүдийн талаар Нийслэл дэх төрийн аудитын газарт очиж холбогдох тайлбар баримт материалыг хүргүүлэн өгч ажилласан.

Хавсралт 6 хуудастай.

 Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
Удирдлага
Дарга
Бэлэгийнжам МӨНХБАТ
2026.05.13 10:25

1725031702503



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР


Наадамдын зам 1201, Ардатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976) 7575 7807
Цахим шуудан: info@ub-procurement.mn
Цахим хуудас: www.ub-procurement.mn

2026.05.14 № 02/1462
танай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭСТ

Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд өгөх санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.



Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
Удирдлага
Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Даваадорж Батцэцэг
2026.05.14 15:07



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН "ЗАХИАЛАГЧИЙН АЛБА" ОНӨААТҮГ

Нутгийн захиргааны нэгдсэн байр,
Баянголлын гудамж 1, 27 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18101
Утас: (976) 7017 7989
Цахим шуудан: shdzaag@gmail.com

2026.05.14 № 349
танай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗАРТ

"Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан, холбогдох саналыг хавсралтаар хүргүүлж байна.

1 дүгээр хавсралт: Хавсралт, 5 хуудастай.
2 дугаар хавсралт: Хавсралт, 3 хуудастай.



Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн Алба ОНӨААТҮГ
Удирдлага
Захирал
Алтанхуяг
2026.05.14 15:33



"СЭЛБЭ ХОРИН МИНУТЫН ХОТ КОРПОРАЦ" ХХК


Соёлын төв өргөө Г корпус, Б Амарын гудамж,
8 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7700 2078
Цахим шуудан: info@selybesty.mn
Цахим хуудас: selybesty.mn

2026.05.14 № 01/316
танай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭСТ

Нийслэл дэх төрийн аудитын газраас ирүүлсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж холбогдох тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 100 хуудастай.



Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК
Захиргаа
Гүйцэтгэх захирал
Улаанхүү Баатар
2026.05.14 12:56



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Тайлбар	Саналд өгөх тайлбар
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	
Тайлбар	Тайлангийн төсөлд өгсөн саналтай танилцаад тайланд найруулгын өөрчлөлт хийлээ.
Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба	
Тайлбар	Тайлангийн төсөлд өгсөн саналтай танилцаад тайланд найруулгын өөрчлөлт хийлээ.
Нийслэлийн Замын хөгжлийн газар	
Тайлбар	Тайлангийн төсөлд тусгагдсан 110 төсөл, арга хэмжээний өмч бүртгэлтэй холбоотой санал ирүүлснээс тайлбарыг үндэслэн 29 төсөл, арга хэмжээг хасаж тайланд өөрчлөлтийг тусгав.
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	
Тайлбар 1	Хуулийг дагаж мөрдөх шаардлагатай тул тус саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 2	Хуулийг дагаж мөрдөх шаардлагатай тул тус саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 3	Саналгүй.
Тайлбар 4	Саналыг хүлээн авах боломжгүй.
Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ	
Тайлбар	Тайлангийн төсөлд өгсөн саналтай танилцаад тайланд найруулгын өөрчлөлт хийлээ.
Нийслэлийн Өмчийн харилцааны газар	
Тайлбар	Саналгүй.
Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ	
Тайлбар	Нийт 7 төсөл, арга хэмжээний илрүүлэлттэй холбоотой асуудалд тайлбар ирүүлснийг нөхөн бүрдүүлсэн нотлох баримтыг үндэслэн 3 зөрчлийг хасаж, 4 зөрчлийг хэвээр үлдээв.
Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК	
Тайлбар	Тайлангийн төсөлд өгсөн саналтай танилцаад тайланд найруулгын өөрчлөлт хийлээ.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Нийслэлийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 118 төсөл, арга хэмжээ (задарсан 469 багц ажил) нь хөгжлийн бодлогод бүрэн нийцээгүй, нийт төсөл, арга хэмжээний 49.8 хувь нь зураг төсөвгүй, газрын зөвшөөрөлгүй зэрэг төсөвлөлтийн шаардлага хангаагүй байхад баталсан нь Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байна.
2. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан төсөл, арга хэмжээний 46.5 хувь нь нэмэлтээр батлагдсан, 57.1 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байгаа нь төлөвлөлт болон бэлтгэл ажил хангалтгүй байгааг харуулж байна. Харин тендерийн шалгуур хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөрчил өмнөх онтой харьцуулахад буурсан эерэг үзүүлэлттэй байна.
3. Төсөл, арга хэмжээний бэлтгэлийг бүрэн хангаагүй (зураг төсөв, газар чөлөөлөлт г.м) баталсны улмаас нийт гэрээний 62.9 хувь нь хугацаа хоцорсон, барилга угсралт, зураг төслийн ажлууд төлөвлөлтийн алдаанаас шалтгаалан удааширсан байна.
4. Захиалагчийн хяналт хангалтгүйгээс 65.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг холбогдох хууль журамд нийцүүлэн олгоогүй байна.
5. НТАГ-аас өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж болон төсвийн төсөлд өгсөн саналуудыг хэрэгжүүлж ажиллаагүй нь алдаа зөрчил дахин давтагдах нөхцөлийг бүрдүүлжээ.
6. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн 49.1 хувийг өмчийн бүртгэлд тусгаагүй байна.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1. НЗД-аас өргөн мэдүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-г төсөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг хянаж, батлах.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах” гэж заасныг мөрдөж, шинээр хэрэгжих ТАХ-г төсөвт батлахгүй байх.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд болон төсвийн жилийн дундуур төсөвлөлтийн шаардлага хангасан ТАХ-г тусгаж, түүнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах.
2. Төсөл, арга хэмжээг хэрэгжилтийн шатанд үндэслэлгүйгээр жижиг багцуудад хуваан (дунджаар 5.3 дахин) зохион байгуулж байгаа болон зарим худалдан авах ажиллагааг ажлын даалгавраар зохион байгуулж байгаа зөрчлийг зогсоох.
3. Гэрээний хугацаа хоцорсон төсөл, арга хэмжээний шалтгааныг тодруулж, гэрээний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах.
4. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний дүнд бий болсон хөрөнгө болон ТЭЗҮ, зураг төсөл, баримт бичиг, тайлан боловсруулах төсөл, арга хэмжээний үр дүнг өмчийн бүртгэлд бүрэн тусгах.
5. Аудитаар илэрсэн зөрчлүүд болон өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох.



ХАВСРАЛТУУД

Хавсралт 1

Зураг төсөвгүй, МЕД-н хугацаа дууссан байхад баталсан ТАХ

(сая.төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
Зураг төсөвгүй.			
1	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын "Агуулах"-ын барилга (Улаанбаатар хот)	1	793.7
2	Шалган нэвтрүүлэх товчооны байр (Улаанбаатар хот)	1	899.3
3	Журмын хашаа барих (Улаанбаатар хот)	1	821.7
4	Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын цахилгааны эх үүсвэрийн ажил	1	20.0
5	Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын тохижилтын ажил	1	20.0
6	Гал түймэр унтраах аврах анги (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	1	6,600.0
7	Гал түймэр унтраах аврах анги (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	1	6,600.0
8	Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо)	1	1,139.7
9	Нийслэлийн Ерөнхий боловсролын 63 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо)	1	13,540.1
10	Багц-1. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг)	1	1,777.2
11	Багц-2. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг) 15 дугаар хороо, 23а,23б,23в байр	1	2,500.0
12	Багц-3. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг)	1	2,015.6
13	Багц-4. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг)	1	550.0
14	Багц-1. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	1	6,128.4
15	Багц-2. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	1	1,418.7
16	Багц-3. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 3, 7 дугаар хороо)	1	430.1
17	Багц-4. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	1	1,480.0
18	Багц-5. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	1	989.6
19	Багц-6. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	1	198.7
20	Багц-1. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг) /12,14,15,17 дугаар хороо/	1	1,812.0
21	Багц-2. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	1	2,438.0
22	Багц-3. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	1	2,544.5
23	Багц-4. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	1	2,085.5
24	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг) 13/1-р байр Багц-1	1	412.8
25	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг) 37-р байрны дээвэр засварын ажил Багц-2	1	70.0
26	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг) 38-р байрны дээвэр засварын ажил Багц-3	1	136.7
27	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг) Голомт хотхоны фасад 5 байр /2,4,6,32а, 39а/ Багц-4	1	2,138.6
28	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг) Голомт хотхоны дээвэр засвар 3 байр /2,4,32а/ Багц-5	1	187.5



Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

29	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг) 4-р байрны фасад Багц-6	1	445.4
30	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг) 40-р байрны дээвэр засварын ажил Багц-7	1	69.2
31	Багц-3. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг)	1	1,820.1
32	Багц-2. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)	1	2,272.0
33	Бейсболын талбай шинээр байгуулах (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	1	1,507.6
34	Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн барилгын засварын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	1	4,500.0
35	"Үндэсний цэцэрлэгт хүрээлэн"-ийн бүтээн байгуулалтын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	1	284.3
36	Гандантэгчлэн хийдийн гадна зам, талбайн борооны ус зайлуулах шугамын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо)	1	581.0
37	Гандантэгчэнлин хийдийн төв талбайн тохижилтын ажил	1	2,645.1
38	Гэрлэх ёслолын ордон"-ны барилга, сантехник, цахилгааны засварын ажил (Улаанбаатар хот)	1	1,000.0
39	Багц 1: А блокийн дээвэр засварын ажил	1	650.0
40	Багц 2: Хөрсний ус зайлуулах, тусгаарлах ажил	1	732.0
41	Багц 3: Барилгын их засвар	1	744.5
42	Шадивлангийн төв замаас Япон цэргийн цогцолбор хүртэлх авто замын ажил (Улаанбаатар хот)	1	1,224.3
43	Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дулааны цахилгаан станц, бохир ус цэвэрлэх байгууламжийн ажил (Улаанбаатар хот)	1	225,500.0
44	Плэйтийм аялал жуулчлалын цогцолбор газар хүртэлх цахилгааны ажил (Улаанбаатар хот, Налайх дүүрэг)	1	530.0
45	Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг) Багц 3	1	368.0
46	Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг) Багц 4	1	450.0
47	Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг) Багц 6	1	23.5
48	Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг) Багц 7	1	419.9
49	Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг)	1	1,760.0
50	Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажил (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг)-Багц-1	1	1,194.1
51	Багц-2-Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажил (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг) 65, 209, 190, 218, 41 дүгээр цэцэрлэг, 60, 114, 26 дугаар сургууль, Эрүүл мэндийн төвийн шугам сүлжээний засвар	1	1,445.9
52	БЗД, 14, 42-р хороо, ХӨСҮТ-ийн Урд талын эцсийн буудлаас зүүн тийш үерийн хамгаалалтын далантай холбогдох болон Цагаанхуаран хотхоноос зүүн тийш далан хүртэлх авто зам - Багц - 1	1	3,707.8
53	БЗД, 13-р хороо, Үерийн хамгаалалтын далангийн авто замаас Сүнжинграндын хажуугаар Энхтайвны өргөн чөлөө болон Нарны замтай холбох авто зам -Багц - 2	1	4,561.7
54	Цагаан давааны авто замаас ландфилийн талбай хүртэл авто зам (Улаанбаатар хот)	1	3,500.0
55	Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт, шинэчлэлт (Улаанбаатар хот, Багахангай дүүрэг)	1	1,000.0
56	Сэлбэ дэд төв орчмын нутаг дэвсгэрийн хөрсний усны түвшинг бууруулах, ус зайлуулах байгууламж байгуулах ажил	1	22,868.1
57	Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол БАГЦ-1 Ус хангамж ариутгах тауурга дулаан механикийн угсралтын ажил, /10.3га/	1	4,921.5
58	Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол БАГЦ-2 Ус хангамж ариутгах тауурга дулаан механикийн угсралтын ажил, /15.3га/	1	10,548.4
59	Зоогийн газрын хоол үйлдвэрлэлийн хэсэг болон хооллох заалны засварын ажил (Улаанбаатар хот)	1	809.6
60	Гадна инженерийн шугам сүлжээ, зам талбайн газар шорооны ажил	1	2,764.0

МЭД-ийн хугацаа дууссан байхад баталсан.



Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

61	Нийслэлийн байгаль орчны газрын конторын барилга (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 19 дугаар хороо)	1	1,162.9
62	Гал түймэр унтраах аврах анги (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	1	6,600.0
63	Зүүн хойд бүсийн одоо байгаа 6000 м3 усан сан дээр нэмж $W=4 \times 6000 \text{ м}^3 = 24000 \text{ м}^3$ -аар өргөтгөн нийт 30000 м3 болгох ажил	1	17,953.9
64	Нийтийн тээврийн граш барих (Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3 дугаар хороо)	1	3,504.5
65	Тоньюукукийн замаас Плэйтайм аялал жуулчлалын цогцолбор газар хүртэлх авто зам, замын байгууламж (Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3 дугаар хороо)	1	18,600.0
66	Улаанбаатар хот, СБД 17 хороо Долоон буудал, Дамбадаржаа орчимд баригдах 2 хэлхээ 110 кВ-ын ЦДАШ, 110/35/10 кВ-ын 2*40кВА чадал бүхий дэд станцын барилга угсралтын ажил	1	17,911.5
67	Багануур үйлдвэрлэл технологийн паркийн дэд станцын ажил, 110/35/10кВ /Улаанбаатар хот, Багануур дүүрэг/	1	9,911.5
68	Жаргалант тосгоны эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	1	6,500.0
69	Хадатын 35/10 кВ-ын дэд станц (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг)	1	8,855.9
70	Хүннү хотын эхний ээлжийн цэвэрлэх байгууламжийн ажил	1	29,663.7
71	Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамжийг нарны замтай холбох (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо)	1	1,953.8
72	Сонгино амралт, суурьшлын бүсийн Туул гол орчмын үерийн хамгаалалтын барилга байгууламж-ийн ажил (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо)	1	5,917.9
73	Нийтийн эзэмшлийн явган хүний замыг шинээр болон шинэчлэн засварлах ажил (Улаанбаатар хот)	1	3,000.0
74	Баянгол дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр "А" хэсэгчилсэн талбайн эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний барилга, угсралтын ажлын үргэлжлэл	1	2,335.3
Нийт		74	498,467.3

Хавсралт 2

Техникийн тодорхойлолтгүй ТАХ

(сая.төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц 1: Автомашин, тээврийн хэрэгсэл нийлүүлсэн эсвэл түүнтэй дүйцэхүйц ажил	1	348.0
2	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц 1: Автомашин, тээврийн хэрэгсэл худалдан авах	1	373.7
3	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц 2: Камер, дуран, зургийн аппарат нийлүүлсэн эсвэл түүнтэй дүйцэхүйц ажил	1	404.8
4	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц-3: Дрон, дагалдах хэрэгсэл	1	139.0
5	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц-4: Зөөврийн, суурин компьютер	1	345.2
6	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц-5: Дагалдах хэрэгсэл тоног төхөөрөмж худалдан авах	1	98.2
7	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц 6: Багаж, гар хэрэгсэл нийлүүлсэн эсвэл түүнтэй дүйцэхүйц ажил	1	556.5
8	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц-7: Дүрс, аудио төхөөрөмж, индэр худалдан авах	1	130.0
9	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц 8: Хувцас, иж бүрдэл нийлүүлсэн эсвэл түүнтэй дүйцэхүйц ажил	1	260.4
10	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц 9: Бусад, тоног төхөөрөмж нийлүүлсэн эсвэл түүнтэй дүйцэхүйц ажил	1	168.0



Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

11	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц 10: Программ хангамж нийлүүлсэн эсвэл түүнтэй дүйцэхүйц ажил	1	357.5
12	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)	1	998.2
13	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) /Цахимаар/ Багц-3	1	1,001.8
14	Онцгой байдлын албанд шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)	1	871.0
15	"Улаанбаатар театр" ОНӨТҮГ-т шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)	1	400.0
16	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц 1 Хогны болон усны машин	1	440.0
17	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц 2 Экскаватор, өөрөө буулгагч, ковш	1	320.0
18	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд шаардлагатай тоног төхөөрөмж Байгаль хамгааллын эргүүлийн машин (Улаанбаатар хот) худалдан авах Багц-3	1	150.0
19	Дуу чимээ, үнэрийн хэмжээг тодорхойлох багаж тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Багц-1	1	500.0
20	Алсын зайн мэдрэгчтэй угаарын хий мэдрэгчийг суурилуулах ажил (Улаанбаатар хот)	1	7,650.0
21	Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар)	1	45,167.9
22	Багц-1 "Соёлын төв өргөө"-ний тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Тайзны лед дэлгэц	1	610.0
23	Багц-2 "Соёлын төв өргөө"-ний тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Лифт	1	798.0
24	Багц-3 "Соёлын төв өргөө"-ний тоног төхөөрөмж (Улаанбаатар хот) Тайзны гэрэлтүүлэг	1	100.0
25	Нийгмийн хамгааллын тусгай төвийн "Сургалт хүмүүжлийн төв"-д шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)	1	896.7
26	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)	1	4,000.0
27	Алсын зайн дамжуулагчтай угаарын болон хийн түлшний мэдрэгч (Улаанбаатар хот)	1	6,750.0
28	Алсын зайн дамжуулагчтай угаарын болон хийн түлшний мэдрэгч (Улаанбаатар хот)	1	9,150.0
29	Авто замын хөдөлгөөн зохицуулах гэрэл дохионы засвар арчлалт болон гэрлэн дохио шинээр суурилуулах	1	1,350.0
30	Өмнөх жилүүдэд суурилуулсан 2750 ширхэг теле камеруудыг хэвийн ажиллагаанд оруулах, Телекамерийн хяналтын нэгдсэн төвтэй холбох ажил (Улаанбаатар хот)	1	512.0
31	Дата төвийн үндсэн болон цахилгааны тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж хэвийн найдвартай аюулгүй байдлыг хангах (Улаанбаатар хот)	1	4,080.6
32	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг)	1	695.0
33	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	1	2,895.0
34	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	1	790.0
35	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг)	1	530.0
36	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх ажил (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг)	1	260.0
37	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх ажил (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)	1	260.0
38	Нийслэлийн Замын хөгжлийн газрын МШТСХ-т шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	1	1,000.0
39	Лабораторийн тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)	1	200.0
40	LCMS (Laser Crack Measurement System) төхөөрөмж болон суурилуулах машин, бүрэн тоноглолтой	1	3,500.0
41	DTIMS программ хангамж	1	500.0
42	Авто замын хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохионы сэлбэг хэрэгсэл нийлүүлэх (Улаанбаатар хот)	1	280.0
43	Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тусгай зориулалтын машин механизм (Улаанбаатар)	1	7,630.3



Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

44	Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тусгай зориулалтын машин механизм (Улаанбаатар)	1	16,084.9
45	"Дижитал твин"	1	5,950.0
46	Нийслэлийн нэгдсэн дата төвд шаардлагатай сервер, тоног төхөөрөмж нийлүүлэх нэмэлт ажил	1	2,300.0
47	Хог хаягдал авах ухаалаг систем	1	2,000.0
48	Нэгдсэн хяналт, удирдлагын төвд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах	1	2,170.8
49	Зоогийн газрын хоол хооллох заалны тавилга, эд хогшил худалдан авах (Улаанбаатар хот)	1	435.6
50	Багц-1: Дунд оврын автобус	1	207.8
51	Багц-2: Задгай тэвштэй ачааны автомашин	1	100.0
52	Багц-3: Задгай тэвштэй жижиг оврын автомашин	1	90.0
Нийт		52	136,806.9

Хавсралт 3

Ажлын тоо хэмжээ, төсвийн тооцоолол тодорхойгүй ТАХ

(сая.төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн
